

БУДДИЗМЫН ДОТОРХИ ЯЛГАРАЛ ҮҮССЭН ТҮҮХЭН УЧИР ШАЛТГААН

М.Гантуяа, МУИС,НШУС,Шашин судлалын тэнхмийн эрхлэгч, дэд профессор

Түлхүүр үгс: Тхеравада, Сарвастивада, Стхавиравада, Вайбхашика, Саутрантика, Йогачара, Мадхьямака

Товч утга: Их хөлгөн дэлгэрсэн газруудад сарвастивада сурвалжуудыг тхеравада сурвалжтай адилтгаж үзэх хандлага байдаг. Үнэндээ тхеравада буюу "өвгөдийн үзэл" хэмээх буддын философийн эхэн үеийн урсгалыг стхавиравада буюу "батад агч аймагтан"-аас гарвал зүйн ялгаатай гэдгийг дэлхийн буддын судлаачид судалгаа шинжилгээгээрээ гаргаж өгсөн байгаа юм. Харин "Сарвастивада" буюу "хамгийг", өөрөөр хэлбэл "хамаг цагийг" буй хэмээн үзэгч аймагтан нь буддистуудын хоёрдугаар чуулганы үеэр тхеравадагаас болон стхавиравадагаас салбарлаж тусгаарлан, улмаар Их хөлгөний философитой нэгдсэн урсгал юм байна. Ийнхүү буддын салбар урсгалууд гарсан гарвалзүйн асуудлыг нарийвчлан судлах шаардлага гарч байна.

* * *

Буддизмыг үндэслэгч Буддагийн амьдрал, үйл ажиллагааг Гандангаас егүүдсэн зохионгуй, Эхийн умайд орсон зохионгуй, Лагшин мэндэлсэн зохионгуй, Урлахуйн оронд мэргэнийг үзүүлсэн зохионгуй, Хатадын хүрээллээр баясан цэнгэсэн зохионгуй, Илт гарсан зохионгуй, Хатуужил эдэлсэн зохионгуй, Бодь модны дэргэд оршсон зохионгуй, Шумнасын аймгийг дарсан зохионгуй, Гэгээрэн бурхан болсон зохионгуй, Номын хүрдийг эргүүлсэн зохионгуй, Гаслангаас нөгчсөн зохионгуй гэсэн арван хоёр зохионгуйгаар гаргадаг. Харин Буддагийн дүр төрхийг "гучин хоёр лагшин" ба "наян найраг" хэмээхийн сургаалаар боловсруулсан байдаг.

Энэтхэгийн эртний нэгэн жижиг Śākya хэмээх овгийн Śuddhodana хааны удам угсааг залгаж, овог үндсээ хөрш зэргэлдээх хүчирхэг Маурын эзэнт гүрний эрхшээлд орох аюулаас аврах төрийн том үүргийг нуруундаа үүрэх тавилантай Siddhārtha Gotama (Gautama) гэгч хан хөвүүн өвөг дээдсээсээ уламжилсан угсаа гарвал, ажил үүргээ сольж холихыг хориглодог энэтхэгчүүдийн (кастын) ёс заншлыг умартан, хаан язгуурт орд өргөө, эхнэр хөвүүн, өсөж торнисон тансаг ариун амьдралаа орхин, бярман хэмээх өөр язгуур угсааныхны эрхэлдэг дияан бясалгал хийхээр гарал үүслээ нуун далдалж, хан хөвүүний баян дээд эдлэл хэрэглэлээ тайлаад, үсээ хусан, улаан орхимжоор биеэ ороож, бадар аяга өвөртлөн Шакьямуни (Шакья овгийн даяанч) нэрээр ой тайгад дүрвэн одсон нь тухайн үедээ олон түмний гайхшралыг төрүүлэхүйц хачирхалтай үйлдэл байлаа.

Ойн бярман багш нараас Ājāra Kāḷāma, Uddaka Rāmaputta хоёроор йогийн ухаан заалгаж, йогийн найман газрыг гүйцээн, юу ч үгүйн газар, хуран мэдэхүй ч бус хуран мэдэхүй үгүй ч бусын газарт хүрч өндөр түвшинд суралцсан боловч өөрийн гэсэн үзэл баримтлалаа дээд онолын түвшинд боловсруулахын тулд одоогийн Bihar-ийн Patna дахь Bodhi Gaya хэмээх газар Bodhi модны дэргэд ганцаар 6 жил бясалгаж, ухаан санаагаа цэгцлэн, насаараа бясалгал хийж номын мөр хөөсөн дияанч мэргэдтэй ном хаялцан

үзэл бодлоо уралдуулах түвшинд өөрийгөө бэлтгэсний эцэст Buddha (гэгээрсэн, боловсорсон) дүрийг олж ном сургаалаа айлдаж эхэлсэн түүхтэй. "Эхлээд хан хүү мэргэн даяанч Багавад бараалхаж түүний хатуу хориг дэглэм бүхий амьдралтай танилцав. Дараа нь Арада Калама, Удрака Рамапудрад бараалхаж бэрх хэцүү хатамжлалыг нь үзэж, тэдэнтэй адилхан дияан хийхийг оролджээ. Удапгүй ийм замаар эс гэгээрэхийг ухаарч Магадха улсад очжээ. Тэнд Гаяа хотын дэргэдүүр урсдаг Ниранзана мөрний эрэгт нэгэн аглаг ойд очиж, биеэ зовоосон хатуухан сорилтыг эхэлжээ... Ингэж өөрийгөө зовоосон ч хан хүү эрж хайснаа, хүсэж хүлээснээ эс олов. Тэрбээр зургаан жилийн турш эр биеэ зовоосон энэхүү хатамжлалаа үл харамсан зогсоож, мөрний усанд угаал үйлдэн, Сужата хэмээх залуухан бүсгүйн гараас сүүтэй будаа авч хүртээд, ядарч сульдсан биеэ анагааж эхэлсэн байна. Ойд түүнтэй цуг хатамжилсан таван даяанч, хан хүү сорилтыг давсангүй хэмээн сэтгэж, ганцааранг нь орхин өөр газар руу нүүн дүрвэжээ. Хан хүү гав ганцаараа хоцорч модны сүүдэрт суугаад хэзээ л бол хэзээ үхэхээс буцахгүй, гүн бясалгалд автав".

Нэгэнт тэр үеийн их сэтгэгчдийн хэмжээнд бие сэтгэл, ухаан мэдлэгээ бэлтгэсэн Шакьямуни философичдын дунд өрнөсөн онолын маргааны бүх асуудлууд, нарийн хийсвэр ойлголт категорууд, арга зүйг системчлэн нэгтгэж, өөр хооронд нь уялдуулан өөрийн гэсэн ертөнцийг үзэх үзэл, философийн баримтлалаараа боловсруулж, байж болох няцаалтуудаас гарах гарц, үндэслэлүүдийг тунгаан, удаан жилийн бясалгал бодрол явуулсны эцэст 35 насан дээрээ 12 сарын 8-ны өглөө үүр цайхын алдад тэрхүү Бодь модны дэргэд сэтгэл нь ариусч, ухаан нь гэгээрэн үнэнийг олсон, өөрөөр хэлбэл эцсийн дүгнэлтээ хийж, өөрийн сургаалыг тунхагласан гэдэг байна. Энэ үеэс эхлэн түүнийг будда буюу "Гэгээрсэн" хэмээн нэрлэх болжээ.

Ийнхүү гэгээрэхдээ нэгд, өөрийн өмнөх төрлүүдийг ухаарч, хоёрт, бусад төрөлхтөний өмнөх болон ирээдүй төрлүүдийг мэдэж, гуравт, өөрийн бүх нисваанисыг дарж нирван (nirvāṇa, nibbāna) болсон гэдэг. Будда Энэтхэг орны газар газраар явж, өөрийн сургаал номлолоо айлдан түгээж, янз бүрийн мэргэдүүдтэй уулзаж учран үзэл баримтлалаа тайлбарлан таниулснаар тэр үеийн философийн бусад урсгал сургуулиас мэргэдүүд хуучин үзлээ орхин, түүний үзлийг баримтлах болсон төдийгүй, нийгмийн бусад бүлгүүд, тухайлбал хаад язгууртан, худалдаачин наймаачин, гар урчууд зэрэг төрөл бүрийн хөдөлмөр эрхлэгчдийн сэтгэлд ч Буддын номлол нийцэн таашаагдаж олон олон шавь дагалдагсад өдрөөс өдөрт нэмэгдсээр байлаа. Юуны өмнө түүнийг орхин одсон таван даяанч нөхөр нь сэтгэлээ биеэсээ тусгаарлаж ариусгана хэмээх үзлээсээ татгалзан түүний анхны шавь болсон бөгөөд тэр үед хойд Энэтхэгийн олон овог, улсуудыг нэгтгэн хүчирхэгжиж байсан Магадха улсын нийслэл Ражагрихэд заларч улсын хаан Бимбасарад (Bimbisāra) номлолоо айлдахуул Буддагийн сургаалын үзэл санаа түүний таашаалд үнэнхүү нийцэж, шавь нь болсноор түүний сургаал Магадха улс даяар түгэн дэлгэрч, тэрхүү хүчирхэг улсын эрхшээлд аргагүй орж байсан Шакья овгийн ард түмэн харин ч Магадха улс даяар хүндлэгдэж эхэлсэн байна. Ийнхүү Будда хан хөвүүнийхээ эрхэм үүргээ номын аргаар

¹ Бурхан багшийн сургаал. Токио. 1196. 6-7 дахь тал.

биелүүлсэн ажээ¹. Будда сургаалаа номлож эхэлсэн үеэс ажил үүрэг, угсаа гарвалаа хольж солихыг хориглодог кастын ёс, нийгмийн анги давхаргын ялгарал арилж, оюун ухааныг дээдлэгч хэн ч болов бодрол бясалгал, номын мөр хөөх боломжтой болсон төдийгүй, төрийн хэргийг зөвхөн цэрэг зэвсгээр бус номын аргаар, хүчирхийллээр бус энх тайванч бодлогоор хэрэгжүүлэх боломжийг нээж өгсөн нь Буддын сургаалын үнэ цэнэ, өнөөг хүртэл дэлгэрэн хөгжиж буйн уг чанар нь мөн болой.

Будда 80 нас хүртлээ номоо айлдан, энгийн сүсэгтэн олноос дияанч мэргэдүүдийг хүртэл, худалдаачид арилжаачдаас хаад язгууртныг хүртэл хэдэн мянган хүнийг сургаалаараа бишрүүлж, Буддын олон олон шавь хуврагуудын нийгэмлэг (saṅgha) бий болсноор буддын сургаалыг даган бишрэгчдийн сахиж мөрдөх зүйл, онол сургаал, мэдлэг ухааны бүхэл бүтэн цогц боловсрол соёл бүрэлдсэн байна. Буддагийн амьдарч байсан тэр цаг үед ном сургаалыг эрт үеэс энэтхэгчүүдийн дунд хөгжсөн яруу илэрхийллийн аргаар зөвхөн амаар айлдаж байсан ба үг хэллэгийн уран эгшиглэнт хэмнэлээр чихэнд дуурсан шингэх номлолыг хэдэн арван "ботиор" нь цээжлэн тогтоох урлаг ухааны ид авьяасынхаа хүчээр бурхан Будда багшийн ном айлдлууд шавиас шавид нь уламжлан хадгалагдсаар нэгэн зууныг өнгөрчээ. Гагцхүү аливаа сургаал онол хөгжин боловсрохын гол үндэс нь шүүмжлэл, хэлэлцүүлэг байдаг тэр л хууль жамын дагуу Буддын сургаалд ч шавь нар нь олон янзын хувилбар, санаа оноог дэвшүүлж, тэр бүрийд Будда өөрийн хариултыг боловсруулан айлдаж байжээ. Ийнхүү асуудалд тал талаас хандаж янз бүрийн түвшний харилцан адилгүй гаргалгааг сонссон шавь нар нь Буддаг таалал төгссөнөөс хойш өөр өөрсдийн сонсож, сурч эзэмшсэн тэр л айлдлыг түшиг тулгуураа болгосон нь Буддын сургаалын олон янзын салбар урсгал үүсэх шалтгаан болсон байна².

Буддагийн амьд сэрүүн үед дагалдаж сургаал номлолыг гажуудуулалгүй цааш дэлгэрүүлсэн хоёр мянга гаруй шавь нарынх нь дотроос хамгийн гол гэгдэх арван шавь байжээ: Махакашьяпа, Ананд, Шарипудра, Маудгальяяна, Упали, Анируддха, Судатта, Пурна, Катьяяна, Субхути. Тэд тус бүрдээ өөр өөрийн авьяас чадвараараа тэргүүлж байсан гэдэг:

1. Sāriputta — mahāpaccānam (их ухаантан бөгөөд Ābhidharma-г эмхэлсэн)
2. Mahāmoggallāna — iddhimantānam (рид хүчит бөгөөд буддын Samādhi-г боловсруулсан)

¹ Буддагийн амьдрал, үйл ажиллагааны намтар түүхийг Ānanda хэмээх Буддын ойрын шавийнх нь удирдлагаар Буддын өөрийнх нь айлтгал, мэтгэлцээн, амьдрал үйл ажиллагааг нь бичиглэн эмхэлсэн анхны эх сурвалж болох пали Судрын аймаг сав (Sutta Piṭaka) номын Accariyabbhutadhamma Sutta // Majjhima Nikāya, Mahāpadāna Sutta // Dīgha Nikāya-Nidānakathā, Mahāvastu, Lalitavistara, Āsvaghosa-гийн Buddacarita зэрэг анхан эртний пали сурвалжуудад домогчлон өгүүлсэн буй. Гэхдээ тэдгээр нь гол төлөв Ниданакатха сударт тулгуурладаг юм. Эдгээр нь сүүлд Majjhima Nikāya-гийн Acchariyabbhutadhamma Sutta, Dīgha Nikāya-гийн Mahāpadāna Sutta-д эмхлэгджээ. Буддагийн намтарыг илүү домогчилсон хэлбэрт оруулсан Ачхариябхутадхамма судар, Дигха Никаягийн Махападана судар гэсэн хоёр сурвалж буй.

² Mahāparinibbāna Sutta (Sūtra of great decease) хэмээх бурхан Буддагийн сүүлчийн айлдал болон Буддизмын олон янз урсгал үүссэн талаар бичсэн анхан эртний сурвалж буй.

3. Anuruddha – dibba cakkhukānam (тэнгэрийн нүдэт)
4. Mahākassapa – dhūtavādānam (онцгой авьяаст)
5. Puṇṇa Mahtāniputta (Pūrṇa Maitrāyaṇīputra) – dhammakathikānam (чадварлаг номлогч бөгөөд Sūtra-г эмхэлсэн)
6. Mahākaccāyana – saṅkhittena bhāssitassa vitthārena atthaṃ vibhajantānam (авьяаслаг тайлбарлагч)
7. Rāhula – 'sikkhākāmānam (гарамгай сонсогч бөгөөд буддын Śrāmaṇera-г боловсруулсан)
8. Revata Khadiravaniya – āraccikānām (онцгой сайн дияанч)
9. Ānanda – bahussutānam (саруул уужим ухаантан бөгөөд bhikkhu багшийн ёсыг боловсруулсан)
10. Upāli – vinayadharānam (винайг хатуу баригч бөгөөд Vinaya-г эмхэлсэн)

Будда бие, сэтгэлийн хатуу ширүүн дияанчлал хийж, харин үнэнийг ухаарахад тохирсон тодорхой хэмжээний бясалгал дияан хэрэгтэй гэж үзэж тийм аргыг боловсруулжээ. Энэ аргыг хадгалж уламжлуулсан анхны шавь нь Махакашьяпа юм. Буддизмд орохоос өмнө тэрээр Бярманы сургаалыг дагадаг байсан бөгөөд тэдэнд өглөг өгөхдөө дуртай байжээ. Гэвч зарим сүсэлдэг байсан бөгөөд тэдэнд өглөг өгөхдөө хүмүүсийг хүндэтгэн бадар баригчид бясалгал хийхийг голлохоосоо өглөг авахыг сонирхдог нь бусдын дургүйцлийг хүлээдэг байв. Харин үнэнхүү бясалгагчдыг хүмүүс бадар аягаа тосоход нь л дуртайяа хооллодог байсан ба Будда болон түүний шавь нар ийм маягаар хооллож, бүх бие сэтгэлээ үнэнийг номлоход зориулж байв. Бурханы шавь нараас бадар барих ёсыг хамгийн зөв гүйцэтгэдэг нь Махакашьяпа байсан ба тиймээс ч тэр буддистуудын анхны нийгэмлэгийнхнийг хооллодог байж, сүүлд нь Буддын шашны ёсонд лам хүний бадар барих ёсыг боловсруулжээ.

Упали, Анирудда, Ананд гурав энэхүү анхны нийгэмлэгт сүүлд элсэн орсон боловч Буддагийн хайртай шавь болцгоосон юм. Буддын нийгэмлэгт тэр үеийн Энэтхэгийн нийгмийн аль ч давхаргаас хүмүүс элсэн ордог байсан бөгөөд Упали бол доод давхаргаас гаралтай хүн байв. Тэрээр винайн ёсыг хатуу мөрддөгөөрөө бусдаас ялгарсан юм. Буддагийн амьдралынх нь сүүлчийн 25 жилд дэргэдээс нь холдолгүй номыг нь сонссон ойрын шавь нь үеэл ах Ананд байлаа. Тэр Буддагийн хэлсэн үг өгүүлбэр бүрийг нэгд нэгэнгүй цээжилжээ. Буддаг нирваан дүр барьснаас хойш тэр буддистуудын нийгэмлэгийг удирдаж байв. Түүний санаачлагаар нийгэмлэгт эмэгтэй хүн орох эрхтэй болсон ба нууц тарнийн ёсыг боловсруулжээ. Анандтай хамт Буддын нийгэмлэгт орж Буддаг номоо айлдах үеэр ёсыг зөрчсөн тул эзмлүүлсэн, гэсэн ч буддын сургаалд үнэнч үлдсэн тул Буддагийн хайрыг хүлээсэн хүн бол Анируддха юм.

Магадха улсын бярманы гэр бүлээс гаралтай, бярманы номлолд багаасаа суралцаж сайтар эзэмшсэн боловч үнэнийг олох хүсэл нь Буддын сургаалд татан оруулж, улмаар буддын философийн гүн мөн чанарыг ухаарсан, шүтэн барилдлагын онолыг нь улам гүнзгий боловсруулсан, буддизмыг Магадха орноо дэлгэрүүлсэн хоёр шавь нь Шарипутра, Маудгальяяна нар билээ.

Вайшьи буюу худалдаачид, гар урчууд, тариачдын эгнээнээс буддизмд орж, түүнийг сайтар судалж дэлгэрүүлэхэд хүчин чармайлт

гаргасан Буддагийн бас нэг хайртай шавь нь Судатта юм. Тэрээр худалдааны ажлаа эрхлэхийн зэрэгцээгээр Буддын номлолыг сурч, хар хүн буддын ёсоор явахад мөрдөх дэг жаягийг боловсруулжээ. Тэр өөрийн хөрөнгөнөөс нэлээдийг буддын нийгэмлэгийн ядуу гишүүдэд өглөг болгосон гэдэг.

Буддаг Магадха болон төв Энэтхэгийн бусад улсуудад номоо айлдаж байх үеэр тэдгээр улсын иргэд төдийгүй бүр алс холын газар орноос хүмүүс зорин ирж ном сонсдог байжээ. Тэдний дотроос худалдаачин байсан Пурна Буддын сургаалыг онцгой эзэмшиж Буддагийн хайртай шавийн тоонд оржээ. Тэрээр буддын сургаалыг уран өгүүлэх, гоё сайхан илтгэх урлагийг боловсруулсан байна. Мөн Ужайн хотын бярман Катьяяна нь Буддаг Саватти хотноо ном айлдаж байх үеэр нь буддизмд оржээ. Түүнийг буддын сургаалын анхны тайлбарлагч гэдэг. Эцэст нь буддын сургаалаас билиг барамид ба хоосон чанарын онолыг нь ухаарч чадсан гэгддэг Субхутиг Буддын арван гол шавийн нэгд зүй ёсоор тооцдог байна. Тэрээр сэтгэл ухаанаа төв барьж, төлөв байдлыг эрхэмлэдгээрээ бусдаас ялгарчээ.

Будда шавь нартаа дараахь арван зүйлийг цээрлэж байхыг сургасан бөгөөд шавь нар нь түүнийг таалал төгссөнөөс хойш ч энэ хориг цээрийг бүгд санал нэгтэйгээр мөрдөж байв. Эрт үеийн энэтхэгийн буддын хуврагуудын үндсэн арван хориг:

1. Siṅgiloṇa kappā (давс үл хэрэглэх)
2. Dvaṅgula kappā (үдээс хойш зоог үл барих)
3. Gāmantara kappā (нэг төрлийн хоолыг өдөрт хоёр удаа үл хэрэглэх)
4. Āvāsa kappā (нэг газрын зан үйлийг өөр газарт үл гүйцэтгэх)
5. Anumati kappā (зан үйлүүдийг өөр хооронд нь үл холилдуулах)
6. Āciṇṇa kappā (өөрийгөө бусдаар үл магтуулах)
7. Amathita kappā (махан хоолны дараа сүү үл хэрэглэх)
8. Jalogim pātum (боловсорч гүйцээгүй жимс үл хэрэглэх)
9. Adasakaṃ nisīdanaṃ (хувцас давхарлаж үл өмсөх)
10. Jātarūparajataṃ (алт, мөнгө үл хэрэглэх)

Буддаг 80 насандаа одоогийн Bihar-ийн ойролцоох Rājagṛha тосгонд таалал төгсөхөд нь түүний сүүлчийн айлдлыг сонсохоор цугларсан 500 гаруй шавь нарынх нь тэр цугларлыг Буддистуудын анхдугаар чуулган хэмээн нэрлэдэг¹. Тэд буддын сургаалыг тасралтгүй дэлгэрүүлэн хөгжүүлэхээ андгайлж, Буддын чандрыг тэр үеийн найман том хотод суврагаар мөнхжүүлснээс үүдэн буддизмын дэлгэрэл хөгжлийн бэлгэдэл болгож найман суврага бүтээх уламжлал тогтжээ. Мөн Будда таалал төгсөхийнхөө өмнө цаашид шавь нарынхаа дунд гарч болох маргааныг таслах дэг жаяг, дүрэм журам боловсруулахыг шавь нараасаа хүссэний дагуу тэд Cullavagga нэрээр алдаршсан Vinaya Piṭaka (Винайн аймаг сав ном) хэмээх буддистуудын сахил санваарын ёс жаягийн талаарх эмхэтгэлийг Upāli хэмээх ойрын шавийнх нь удирдлагаар боловсруулжээ. Винайн болон Судрын аймаг сав ном нь нийт 30 гаруй боть зохиол байх ба эдгээрийг цээжээр мэдэх хуврагууд өнөөг хүртэл Шри-Ланк, Тайланд, Бирм зэрэг тхеравада буддизмын орнуудад уламжлагдсаар байгаа аж.

¹ Буддистуудын анхдугаар чуулганы талаар францын буддын судлаач A. Bareau "Les premiers conseils bouddhiques" (Paris 1955) номондоо судлан тайлбарлажээ.

Анхдугаар чуулганаас хойш нэгэн зуун (бүр тодруулбал, 110, эсвэл 137 жил¹) өнгөрч шавь нар нь Буддын сургаалыг бичгээр эмхлэн хадгалахыг чухалчлах болсноор ойролцоогоор мээ 380 оны үест өнөөгийн Patna-гийн ойролцоох Vaiśālī-д Буддистуудын хоёрдугаар чуулган болжээ. Анхдугаар чуулганаар бүрэлдсэн Винайн ёсыг тэр хэвээр нь баримтлахыг чухалчилдаг Буддын гол төлөв ахмад буурал шавь нар энд цугларснаас үүдэн тэднийг Sthaviravāda буюу Theravāda (Өвгөдийн талынхан) гэх болсон ба харин винайн ёсонд зарим өөрчлөлт оруулах, мөн буддын сургаалыг илүү гүн нарийн түвшинд боловсруулах эрмэлзэлтэй Mahāsāṅghika (олонхийн бүлэг) хэмээх өөр нэгэн хэсэг шавь нар нь Mahādeva-гаар удирдуулан одоогийн Patna буюу тэр үеийн Pāṭaliputra-д тусдаа чуулжээ². Тэд arhat хэмээх ойлголтыг bodhisattva-гийн асуудалд дэвшүүлснээрээ буддын ёсзүйн сургаалыг гүнзгийрүүлэн философийн монизмыг боловсруулсан юм.

Харин Theravāda ёсныхон тухайн үедээ нэгдмэл байгаагүй, бүр 17 урсгал чиглэл болон салбарлаж байсан хэмээн Mahāvamsa сурвалжид өгүүлсэн буй. Mahāsāṅghika нь өөрсдийгөө Mahāyāna (Их хөлгөн) хэмээн нэрлээд, харин дээрхи 17 урсгалыг Hīnayāna (Бага хөлгөн) хэмээн нэрийн дор бүгдийг шүүмжлэн няцаасан³ гэх боловч янз бүрийн сурвалж, судалгааны номуудад энэ талаар арай өөр тайлбаруудыг өгдөг.

Cullavaga сударт өгүүлснээр, буддистуудын хоёрдугаар чуулган болсон тэр цаг үед буддын хуврагуудын дотор Sabbakāmi, Sāḷha, Revata, Khujjasobhita, Yasa, Sambhūta Sāṇavāsī, Vāsabhagāmika, Sumana хэмээх найман гол багш⁴ хуврагуудын нийгэмлэгийг тэргүүлж байжээ.

Тэдний дотроос хамгийн идэвхтэй гэгдэх Yasa багш анх Gange мөрний эхэн дэх Ahogaṅga ууланд Mathurā-ийн Sambhūta Sāṇavāsī багштай, дараа нь Kanauji-ийн sthavira Revata (сүүлд нь хуврагуудын нийгэмлэгийн ахлагч болсон) багштай Soreyya-д, эцэст нь Sumana багштай уулзсанаар Pāvā (Pāveyyakā, Pāṭheyya)-ийн 60 theravāda-чууд, Avantī-ийн 80 theravāda-чуудыг буддын нийгэмлэгийн өрнөдийн бүлэг болгон зохион байгуулж Rājagṛha-д, дараа нь Pāṭaliputra-д нэгтгэжээ. Гэхдээ Revata багш эхэн үедээ түүнтэй бүрэн санал нэгдээгүйн учир Sahajāti-д өөр хуврагуудтай чуулсан гэдэг. Энэхүү Sahajāti-ийн Sāḷha хэмээх хувраг Revata, Yasa хоёрын дунд нэгэн хэсэг хэлбэлзэж байгаад Yasa багшийн талд нэгдсэн ба Yasa-гийн байгуулсан өрнөдийн бүлэг нь Mathurāд төвлөрсөн өмнөд-өрнийн Sarvāstivādin бүлэг ба Kauśāmbī-д төвлөрсөн умард-өрнийн Theravādin (Sthavirā) бүлэг хэмээх хоёр бүлэгт хуваагдсан байна. Sthaviravādin-чууд

¹ Nalinaksha Dutt, Buddhist Sects in India, Delhi, 1998, p. 14

² Буддистуудын хоёрдугаар чуулганы талаар Cullavagga, Mahāvamsa, Dīpavamsa, Samantapāsādikā, Mahābodhiṃsa, Sāsanavamsa зэрэг пали судрууд, Maṃjuśrī-mūla-kalpa хэмээх санскрит сурвалж, Dul-va хэмээх төвд сурвалж, Vasumitra (мэ 100 оны үе), V-VI зууны үеийн сэтгэгч Bhāvaviveka, Vinītadeva, мөн үеийн түүхч Paramārtha нарын зохиол бүтээл, Bu-sTon, Tāranātha нарын бичсэн бурхан шашны түүхийн сурвалжуудад дурдсан буй.

³ Noble Ross Reat, The Historical Buddha and His Teachings // Encyclopedia of Indian Philosophy, Volume VII, p. 23

⁴ Bu-sTon-гийн номонд Sarvakāmin, Śāḍha, Revata, Kubjita, Yaśas, Sambhūta, Dhanika, Ajita гэсэн өөр нэрийн жагсаалт буй.

буддын хуврагуудын баримтлах дэг ёсонд нэмэлт оруулсан Mahādeva-гийн таван зарчмыг хүлээн зөвшөөрчээ. Үүнд, Atha (bhikṣu, хувраг багш) нь:

1. Хүсэн тэмүүлэх зүйл мөн,
2. Нисванисын эчүүхэн хувьтай байж болно.
3. Тодорхой зүйл дээр сэжиг байж болно.
4. Бусдын туслалцаатайгаар мэдлэг олж авна
5. "Ахо" хэмээн уулга алдаж мөрд орно.

Эндээс нэгд, сахил санваарын ёс ба хоёрт, онол сургаалын ёс гэсэн хоёр талаас асуудлыг тус бүрд нь авч үзэх хоёр бүлэг гарчээ. Эдгээр бүлэг салбаруудын үйл ажиллагааг нэгтгэх зорилгоор зарим хуврагуудын хүсэлтээр Pupphapura-гийн Kālāsoka (Aśoka) хаан Vaiśālī-ийн¹ ойролцоох Pāṭaliputra-д 700 хуараг оролцсон буддистуудын хоёрдугаар чуулганыг Энэхүү хоёрдугаар чуулганыг Bāṇa багш даргалжээ.

Vaiśālī хот нь эхэндээ Nigaṇṭha Nāṭaputa-г даргасан Буддын бус гадаад тогтсон таагалтны төв хот гэж тооцогдож байж. Гэвч Sabbakāmi, Sāḷha, Khujjasobhita, Vāsabhagāmika нарын буддын хуврагууд нэгдэж эхлээд Avantī-д, дараа нь Vaiśālī-д, эцэст нь Pāṭaliputra-д төвлөрч буддын нийгэмлэгийн дорнод хэсэг (pācinakā), **Mahāsaṅghika** (Mahāsaṅgha, Mahāsaṅgīti) бүлэг болж, хоёрдугаар чуулганы үеэр өрнөдийнхнөөс тусдаа чуулсан гэдэг. Ингээд найман гол багшаас Sabbakāmi, Sāḷha, Khujjasobhita, Vāsabhagāmika дөрөв дорнод бүлгийнхэн буюу Mahāsaṅghika болж, Revata, Yasa, Sambhūta Sāṇavāsī, Sumana дөрөв өрнөд бүлгийг буюу Sthavirā-г төлөөлөх болжээ.

Хоёрдугаар чуулганы үеэр Mahādeva багш Mahāyana sūtra-г бичсэн гол хүний хувьд тэдгээр судраа Tripiṭaka-д оруулахыг оролдож байжээ. Харин Paramārtha нь Sthavira ба Mahāyana-ийн хсоронд хэлбэлзэж, улмаар Vijnānavāda-г баримтлах болсон аж. Их хөлгөнийхөн Manjuśrī болон бусад Bodhisattva нарыг даган суралцах болжээ.

Vinītadeva-гийн мэдээлж байгаагаар², хоёрдугаар чуулганы дараа буддын хуврагийн нийгэмлэг нь үндсэн дөрвөн бүлэг, 18 урсгалд хуваагдсан байна. Тэдгээрийн зарим нь Tāranātha-гийн зохиолд арай өөр нэрээр бичигдсэн буй:

1. Mahāsaṅghika (Tāranātha: Ekavyavahārika) нь Pūrvaśaila (Tāranātha: Caityaka, Mahādeva-гийн тал), Aparāśaila, Haimavata, Lokottaravāda (Tāranātha: Kaukkuṭika), Prajāpativāda гэсэн таван урсгалд,

2. Sarvāstivādin нь Mūlasarvāstivāda, Kāśyapīya (Tāranātha: Suvarṇaka), Mahīśāsaka, Dharmagupta, Bahuśrutīya, Tāmraśāṭīya (Tāranātha: Saṃkrāntivādin, Uttarīya), Vibhajyavāda гэсэн 7 урсгалд,

3. Sāṃmitīya нь Kaurukullaka (Tāranātha: Vātsīputrīya, Dharmottarīya, Bhadrāyānīya), Avantaka, Vātsīputrīya гэсэн 3 урсгалд,

4. Sthavira нь Jetavanīya, Abhayagirivāsin, Mahāvihāravāsin гэсэн 3 урсгалд тус тус салбарлажээ.

¹ Mahāsaṅghika Vinaya сударт Vālukārāma хийдэд, Bu-sTon-гийн номонд Kusumapura хийдэд болсон гэх мэтээр өөр өөр хийдийн нэрийг сурвалжуудад дурдсан байгаа нь өөр өөр бүлгийн тус тусдаа чуулган болсныг илтгэнэ.

² Nalinaksha Dutt, Buddhist Sects in India, Delhi 1998, p.49

Тхеравада чиглэлийнхэн анх буддын философийн бүх ойлголт ухагдахуун, асуудал, бүлгүүдийг тогтоож эмхэлж өгөх үйл ажиллагааг эхлүүлсэн ба тэдний гол зорилго нь бурхан Буддагийн амаар айлдаж байсан номлол сургаал, мэтгэлцээн хэлэлцүүлгүүдийг тухайн үеийн Энэтхэгийн уламжлалт философи сэтгэлгээний хүрээнд оруулж системчлэх явдал байжээ. Харин сарвастивада чиглэлийнхэн тхеравадагийн системчилсэн буддын философийн ойлголтуудыг өөрсдийн үзэл баримтлалдаа нийцүүлэн боловсруулснаараа өвгөдийн уламжлалт баримтлалаас өөр шинэ хандлагыг төрүүлж өвөрмөц өгүүлэгч буюу Вайбхашика философийг бүрдүүлжээ. Иймээс буддын философийг тодорхой урсгалын ном зохиолын үзэлд баригдуулалгүй, анхан эртний уламжлалт арга зүйгээр нь хандвал бидний судалгаа илүү цогц оригинал шинжтэй болох боломжтой гэж үзэж байна. Мөн эртний Энэтхэгийн буддын олон урсгалын гарвал зүйн асуудлыг улам тодруулах ажил манай судалгаанд үгүйлэгдэж байгаа юм.